



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №28



2018 оны 8-р сарын 13-17-ны хооронд

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчний сэжигтэй байж болзошгүй нийт **1157** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 104(9.0%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1028(88.9%) хачигт халдвар, 11(0.9%) бэтэг, 1(0.1%) хумхаа, 7(0.6%) боом, 6(0.5%) тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:


Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын **1028** сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17%-иар бага байна. Эпидемиологийн 32-р долоо хоногтой харьцуулахад 11 сэжигтэй тохиолдлоор их байна.



8 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар хачигт риккетсиозын 763 сэжигтэй тохиолдлын 185(24.2%), хачигт энцефалитын 174 сэжигтэй тохиолдлын 32(18.4%), хачигт боррелиозын 87 сэжигтэй тохиолдлын 24(27.6%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдаж, 129 тохиолдлын онош үгүйсгэгдээд байна.

1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:


Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт **104** тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 12%-иар бага байна. Эпидемиологийн 32-р долоо хоногтой харьцуулахад 4 эрсдэлд өртсөн тохиолдлоор их байна.



Эх сурвалж: Ховд аймгийн ЗӨСТ

Мал, амьтны боом өвчин:

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын малчин айлын 2 тугалд мал, амьтны боом өвчний шинж тэмдэг илэрч, дээж авч Аймгийн Мал эмнэлгийн лабораторид шинжлүүлэхэд 8-р сарын 14-ний өдрийн шинжилгээний дүнгээр мал, амьтны боом өвчин болох нь тогтоогдсон. Тус голомтод нутгийн 1 өрх айлын 4 хүнд үзлэг хийж, 5 өрх айлын 15 хүнд боом өвчнөөс сэргийлэх сурталчилгаа хийгдсэн.




Эх сурвалж: Хөвсгөл аймгийн ЗӨСТ

Олон улсад:

Эбола вирус халдвар:

БНАК улсын Уганда улстай хил залгаа Хойд Киву мужид (сая гаруй хүн амтай) 8-р сарын 01-нд Эбола вирус халдварын сэжигтэй 6 хүнээс 4 нь эбола вирусийн халдвартай болох нь тогтоогдсон тухай Нийслэл Кишанса хот дахь Био-Анагаах ухааны судалгааны үндэсний хүрээлэнгээс зарласан. 8-р сарын 09-ний байдлаар Хойд Киву мужийн (Mabalako, Beni, Butembo, Oicha, Musienene), Итури мужийн (Mandima) эрүүл мэндийн төвөөс нийт 44 сэжигтэй (17 батлагдсан, 27 болзошгүй) тохиолдол, үүнээс 36 нас баралт мэдээлэгдээд байна. Тус улсын Хойд Киву, Итури мужуудад Эбола вирусийн дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажиллаж байна.



Эх сурвалж: ДЭМБ

Мал, амьтны галзуу өвчин:

Малайз улсын Сарабак хотын Кучинг мужид мал, амьтны галзуу өвчин бүртгэгдэж, 1900 нохой өртсөнөөс, 7 нохой өвчилж, 28 нохойг устгасан байна. Тус мужид хязгаарлалтын дэглэм тогтоосон байна.



Эх сурвалж: ДЭМБ

Шүлхий өвчин:


БНХАУ-ын Нийслэл Женжоу хотын Хэнань мужид “О” хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхий өвчин бүртгэгдэж, 173 гахай өртсөнөөс, 5 гахай өвчилж, 173 гахайг устгасан байна. Тус мужид хорио цээрийн дэглэм тогтоож, хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДЭМБ

Африкийн гахайн мялзан:

Латви улсын Мадонас мужийн ойд Африкийн гахайн мялзан өвчний улмаас 5 зэрлэг гахай өвчилж, 1 зэрлэг гахай өвчилж үхэн, 4 зэрлэг гахайг устгаж, халдваргүйтгэл хийжээ.



Эх сурвалж: ДАЭМБ

Жич: Энэ долоо хоногт Архангай, Баянхонгор, Дундговь, Завхан, Хөвсгөл, Ховд, Өмнөговь аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн. Салбар төвүүд ШУН-ийн eop@nczd.gov.mn мэдээгээ ирүүлж байна уу?